БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 5 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2026/056/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2026 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ужим Алтай Аудит ХХК-ны Захирал: Г.Ганболд<br>Утас: 99117121 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2026. 02. 25 № 227

танай________-ны №__________-т

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН 5 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
К.АСЕМГҮЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэг нь 2025 онд 1,204.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,196.1 сая төгрөг зарцуулж, 99.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

832605000143

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

| Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,204,129,100.00** | **1,196,106,168.05** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,204,129,100.00 | 1,196,106,168.05 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,204,129,100.00 | 1,196,106,168.05 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **835,308,800.00** | **832,659,249.05** |
| Үндсэн цалин | 555,209,400.00 | 555,209,400.00 |
| Нэмэгдэл | 246,912,700.00 | 227,900,701.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | - | 14,155,000.00 |
| Урамшуулал | 33,186,700.00 | 35,394,148.05 |
| Гэрээт ажлын хөлс | | |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **103,622,800.00** | **103,127,700.00** |
| Тэтгэврийн даатгал | 70,290,200.00 | 69,952,300.00 |
| Тэтгэмжийн даатгал | 8,333,100.00 | 8,295,200.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 4,166,600.00 | 4,146,700.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 4,166,600.00 | 4,146,700.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 16,666,300.00 | 16,586,800.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **138,926,900.00** | **138,926,900.00** |
| Гэрэл, цахилгаан | 17,066,000.00 | 12,580,813.00 |
| Түлш, халаалт | 102,799,900.00 | 105,760,111.00 |
| Цэвэр, бохир ус | 19,061,000.00 | 20,585,976.00 |
| **Нормативт зардал** | **92,458,900.00** | **88,239,919.00** |
| Хоол, хүнс | 92,458,900.00 | 88,239,919.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,700,000.00** | **4,700,000.00** |
| Урсгал засвар | 4,700,000.00 | 4,700,000.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,080,800.00** | **3,562,500.00** |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,080,800.00 | 3,562,500.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **25,030,900.00** | **24,889,900.00** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 17,491,600.00 | 17,450,800.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,539,300.00 | 7,439,100.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,204,129,100.00** | **1,081,326,800.00** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 938,465,400.00 | 937,559,900.00 |
| Улсын төсвөөс санхүүжих | 938,465,400.00 | 937,559,900.00 |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 143,626,900.00 | 143,626,900.00 |
| Орон нутгийн төсвөөс | 143,626,900.00 | 143,626,900.00 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 122,036,800.00 | 140,000.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 140,000.00 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 122,036,800.00 | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 103425791.70 | 137,970,503.70 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 137970503.70 | 23,191,135.65 |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 0.00 | 33.00 |
| Удирдах ажилтан | - | 1.00 |
| Гүйцэтгэх ажилтан | - | 22.00 |
| Үйлчлэх ажилтан | - | 10.00 |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой 976.3 сая төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад 976.3 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан. *Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс санхүүжих 976.1 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгалгүйгээр алдаатай тайлагнасан.
- Мөнгөн гүйлгээний тайланд норматив зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 0.2 сая төгрөгөөр илүү, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр албан шаардлага өгөгдөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТГТ-г зөрүүтэй тайлагнасан | 1 | 976,148.0 | 1 | 976,148.0 | | | 1 | 976,148.0 | | | | |
| Мөнгөн үйлчилгээний тайланг зөрүүтэй илэрхийлсэн. | 1 | 190.5 | | | 1 | 190.5 | 1 | 190.5 | | | | |
| **Дүн** | 2 | 976,338.5 | 1 | 976,148.0 | 1 | 190.5 | 2 | 976,338.5 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |